

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2022/16-ШТА-ГА

ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХОЛБОГДОХ ЖУРМЫН ДАГУУ САНАЛ АВЧ ТӨЛӨВЛӨӨГҮЙ,
ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД ТАВИХ ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫГ ХАНГАЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Б.Нарангэрэл
Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn

Баянхонгор хот 2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА, АЧ ХОЛБОГДОЛ, ҮР АШГИЙН ТООЦООЛОЛ ХИЙХГҮЙ БАЙНА. 5	
А.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн, хууль, тогтоомжид заасан шалгуурт нийцүүлэн төлөвлөөгүй байна.	6
А.2. Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 28 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээ нь Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөтэй нийцээгүй байна.....	8
БҮЛЭГ 2. 10	
Б.1.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хэрэгжих боломжит хугацаанд зохион байгуулаагүйгээс хөрөнгийн үр ашиг бүрэн гараагүй байна.....	10
Б.2. Аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ийн авто зам хариуцсан мэргэжилтэн хяналт хэрэгжүүлээгүй байна.	17
Б.3. Төсөл, арга хэмжээний аймгийн ИТХ-аар батлагдсан төсвийг 4.5 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн, хөрөнгө оруулалтаар бий болсон 193.7 сая төгрөгийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоож хөрөнгөд бүртгээгүй байна.	23
Б.4.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа, зөрчил давтагдан гарсаар байна.....	25
ДҮГНЭЛТ: 28	
ЗӨВЛӨМЖ:	29

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТАХ	Төсөл, арга хэмжээ

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2022 оны А/11 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв батлах тухай”, А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийв
Аудитын зорилт	“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.
Аудитын хамарсан хүрээ	Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх ➤ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх
Аудитын хязгаарлалт	Аудитыг аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Орон нутгийн өмчийн газар, 2021 онд орон нутгийн “Ангилалдаагүй зардал”-ын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээ, “Авто замын сан”-гийн хөрөнгөөр батлагдсан хөрөнгө оруулалтыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	Аудитад ангилагдаагүй зардалд багтсан хөрөнгө оруулалтын бус шинж чанартай хөтөлбөр, арга хэмжээнүүд, замын сангийн орлого бүрдүүлэлтийг хамааруулан шалгаагүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүй, Монгол Улсын стандарт-Төрийн аудит MNS6817:2020-ыг ашиглан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторовн баталсан төлөвлөгөөг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, үндсэн үзүүлэлтийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Нарангэрэл нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитын төлөвлөгөөг 2022.03.10-ний өдөр батлуулж, талбарын ажлыг 2021.03.28-ны өдрөөс 2021.04.20-ний өдөр хүртэл гүйцэтгэж, аудитын тайланг 2020.04.29-аас холбогдох үе шатны хяналтаар хянуулан газрын дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар, аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.
	1. Аймгийн Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс холбогдох судалгааг заасан хугацаанд гаргаж өгөөгүйгээс аудитыг цаг хугацаандаа гүйцэтгэж дүнг танилцуулахад хүндрэл учирсан болно.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. Замын сангийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө холбогдох журамд заасны дагуу санал авахгүй байгаа нь төлөвлөлтийн үр дүнг бууруулж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/9 дугаар тогтоолоор Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд нийт 41 арга хэмжээнд 1,100.0 сая төгрөг баталсан, аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны хуралдааны 3/10 дугаар тогтоолоор 1 удаа тодотгож 50 төсөл арга хэмжээнд нийт 1,431.3 сая төгрөгийн төсөв баталсан.

Аудитаар 2021 аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 15 төсөл, арга хэмжээний 540.3 сая төгрөгийг түүвэрлэн авч үзлээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 2/9 тоот тогтоолын 5 дугаар хавсралтаар Замын сангийн хөрөнгө оруулалтаар 10 ажилд 895.0 сая төгрөг, 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 3/10 тоот тогтоолын хавсралтаар 12 төсөл арга хэмжээнд төсвийн үлдэгдлээс 12.1 сая, 2020 оны давсан орлогоос 120.6 сая, авто зам ашиглалтын хураамжаас 240.0 сая, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвараас 575.0 сая, нийт 947.7 төгрөгийг санхүүжилтийг зарцуулахаар тус тус баталжээ.

Хүснэгт 1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа

Төсөл арга хэмжээний нэр	Анх баталсан		Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны №3/10 дугаар тогтоолоор тодотгосон	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Замын сан	10	895	12	947.7
Ангилалдаагүй зардал	11	418.4	15	540.3
НИЙТ ДҮН	21	1313.4	27	1488.0

Эх сурвалж: Аймгийн ИТХ-н хуралдааны тогтоол

Авто замын тухай хуулийн 14.3¹-т заасны дагуу Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/9 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийг батлахдаа замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,795.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээнд 895.0 сая төгрөг, 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 3/10 дугаар тогтоолоор 52.7 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг нэмж тодотгон нийт 947.7 сая төгрөгөөр баталсан байна.

¹ нийслэл, орон нутгийн чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг дарга олон улс, улсын чанартай авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуула.

А.1. Ангилалдаагүй зардлын 3 төсөл арга хэмжээ дунд болон богино хугацааны бодлоготой уялдаагүй ба замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох газруудаас санал аваагүй байна.

А.1.1. Аудитаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх нийт 23 төсөл арга хэмжээг хамруулсан бөгөөд үүнд орон нутгийн “Ангилалдаагүй зардал”-ын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 15 төсөл арга хэмжээ, “Авто замын сан”-гийн хөрөнгөөр батлагдсан 8 хөрөнгө оруулалтыг хамруулан үзсэн бөгөөд дээрх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг буюу Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдсан эсэхийг тулган шинжлэхэд дараах зөрчил илэрлээ.

Хүснэгт 2: Төсөл, арга хэмжээний хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдийн уялдаа

Зардлын төрөл	Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр		Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө	
	Уялдсан ТАХ-ны тоо	Уялдаагүй ТАХ-ны тоо	Уялдсан ТАХ-ны тоо	Уялдсангүй ТАХ-ны тоо	Уялдсан ТАХ-ны тоо	Уялдсангүй ТАХ-ны тоо
Ангилалдаагүй зардал	8	7	10	5	12	3
Замын сан	1	7	8	0	8	0
Дүн	9	14	18	5	20	3

Эх сурвалж: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүд

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 14 төсөл арга хэмжээ нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 3 төсөл арга хэмжээ нь аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна. Тухайлбал:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж,
- Шүүхийн шинжилгээний албаны автомашин,
- Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, Цэвэр хот оффис худалдан авах ажлууд аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.26², 6.1.10³ дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6.4⁴ дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.1.2 Аймгийн Засаг даргын ангилалдаагүй зардлаас тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ашиглагч байгууллагаас ирүүлсэн санал, албан бичгийг үндэслэн төлөвлөсөн байна.

² Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;

³ орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 6.2-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон материалыг хавсаргасан байна.

Харин аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь тайлант онд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 893.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дээрх журамд заасан шалгуур үзүүлэлтийг тооцоогүй байна.

Аудитын илрүүлэлт:

Замын сангийн 2021 оны хөрөнгө оруулалтаас 893.8 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө баг хороо, авто тээврийн төв, замын цагдаа зэрэг холбогдох байгууллагуудаас санал аваагүй байгаа нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6.4.3⁵-т заасан шалгуурыг хангахгүй байна.

Иймд Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2⁶ дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөж аймгийн ИТХ-аар батлуулж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

A.1.3 Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгцээг шаардлагаар нь эрэмбэлэн, нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлж жагсаалт гарган бэлтгээгүй, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2⁷-д заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар Баянхонгор аймгийн хэмжээнд 2021 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд батлагдсан 23 төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл явцын талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтнүүдийн ирүүлсэн судалгаанаас үзэхэд төсөл, арга хэмжээг дээрх журамд заасан шалгуурт нийцүүлэн нэгтгэн дүгнэж, шинжилгээ хийгээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ баримтжуулдаггүй, анхан шатны нэгжээс хэрэгцээ шаардлагын талаар судалгаа авдаггүй, хөрөнгө оруулалтын үр ашгийг урьдчилан тооцдоггүй аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь төлөвлөлтийн үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 6.4⁸-т заасан шалгуурыг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ аймгийн хэмжээний төсөв захирагчдын хэрэгцээ шаардлагыг судалж, хэрэгцээ шаардлагыг эрэмбэлэн, хүрэх түвшнийг тодорхойлон, эдийн засгийн үр ашиг, нийгмийн үйлчилгээний хүртээмж, бусад холбогдох ач холбогдлоор нь

⁵ Хэрэгцээ шаардлага, үндэслэл.

⁶ Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх дараахь шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй:

⁷ Төсөл арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл арга хэмжээнүүдийг тодорхойлж, жагсаалт гаргах.”

⁸ ТЭЗ нь энэ журмын 6.2-д заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийн хангаж буй судалж холбогдох тайлан болон материалыг хавсаргасан байна.

эрэмбэлэн төлөвлөлтийг зохистой хийх чиг үүргээ хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, алдаа, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.2. Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 98.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

А.2.1. Аудитаар тайлант онд төлөвлөсөн 23 төсөл арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17⁹-д заасан төсөвлөлийн шаардлагыг хангуулж, төлөвлөсөн эсэхийг шалгав. Үүнд:

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнээс 98.0 сая төгрөгийн 3 арга хэмжээ нь Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдээгүй байна.

Тухайлбал: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж, Шүүхийн шинжилгээний албаны автомашин, Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, “Цэвэр хот” ОНӨААН-д оффис худалдан авах ажлууд нь Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Хүснэгт 3 Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээ

Төсөл арга, хэмжээний нэр	Батлагдсан төсөв	Санхүүжсэн дүн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж	20.0	20.0
Шүүхийн шинжилгээний албаны автомашин	36.0	39.7
Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, Цэвэр хот оффис ХАвах	42.0	42.0
НИЙТ ДҮН	98.0	101.7

Эх сурвалж: аймгийн хөгжлийн төлөвлөгөө

Замын сан:

Аймгийн Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөвлөхдөө техникийн хяналт хэрэгжүүлэх зардлыг Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-д заасан хэмжээнээс 5.5 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд замын сангийн хөрөнгөөр 947.7 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 3.2.5¹⁰-д заасныг баримтлаагүй нийт төсөвт өртгийн 15.8 хувийг техникийн хяналтын зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Иймд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолоор баталсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх,

⁹ “төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулах”

¹⁰ Төсвийн 10 хүртэлх хувийг Авто замын тухай хуулийн 24.5-д заасан үйл ажиллагаанд” төлөвлөж хуваарилна

захиран зарцуулах журам”-д нийцүүлэн төлөвлөж, аймгийн ИТХ-аар батлуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

A.2.2 Аудитаар тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 1176.5 сая төгрөгийн 23 төсөл арга хэмжээ, мөн өмнөх оноос шилжсэн замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 296.2 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, ИТХ-аар батлагдаагүй 35.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, нийт 1507.7 сая төгрөгийн 28 төсөл арга хэмжээг хамруулав. Үүнд:

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих дүнг батлахдаа ангилагдаагүй зардлаас санхүүжих 540.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тайланд онд бүрэн олгохоор баталсан байгаа нь төсөл арга хэмжээнүүдийг тайлант онд бүрэн хэрэгжих боломжоор хангасан байна.

Замын сан:

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 2,165.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнд тайлант онд 947.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталснаас өмнөх онуудад хэрэгжсэн 1,256.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 арга хэмжээний 296.2 сая төгрөгийн дутуу санхүүжилтийг тайлант онд олгохоор төлөвлөсөн байна.

Шинээр хэрэгжүүлэх 893.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ, 15.0 сая төгрөгийн захиалагчийн хяналтын зардал, нийт 651.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас 514.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 арга хэмжээг тайлант онд бүрэн санхүүжүүлэхээр төлөвлөөгүй байна.

Тухайлбал: "Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх 514.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг тайлант онд 409.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан ба аудитын явцад ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад ажлыг хийж гүйцэтгэсэн ажлын хэсэг ажлыг хүлээж авсан байна.

Харин “Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфалтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах 99.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын 37.0 сая төгрөгийг замын сангаас 62.9 сая төгрөгийг аймгийн ОНХС-аас, Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфалтан замын хашлаг бордюр хийх 66.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын 27.0 сая төгрөгийг замын сангаас 39.9 сая төгрөгийг Бууцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

A.2.3 Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3¹¹-т заасан хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

Харин аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардлаас зөвхөн хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээг түүвэрлэн шалгав.

БҮЛЭГ 2. Баянхонгор аймагт 2021 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1427.3 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж, 56.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Б.1.2.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг хууль, журамд заасан хугацаанд эрх шилжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хугацаа алдаж зохион байгуулснаас 37.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.

Б.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 684.8 сая 6 төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6¹²-д заасны дагуу эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Ангилагдаагүй зардалд 2021 онд батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-ээс 43.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт эрх шилжүүлсэн бөгөөд харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалтыг зарласан байна.

Замын сан:

Замын сангийн хөрөнгөөр 2021 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан нийт 610.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээнд аудит хийв.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 496.8 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг Баянхонгор сумын ЗДТГ, 27.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг Бууцагаан сумын ЗДТГ-т эрх шилжүүлсэн бөгөөд үүнээс 1 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалтыг зарласан байна.

¹¹ Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

¹² Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно

Хүснэгт № 4 Замын сангийн хөрөнгийн 2021 онд эрх шилжүүлсэн төсвийн судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг	Эрх шилжүүлсэн байгууллага	Эрх шилжүүлсэн огноо	Эрх шилжүүлсэн дүн
1	"Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх	514.6	Баянхонгор сумын Засаг дарга	2021.04.09	514.6
2	Аймгийн төв доторх хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил 880 м2	45.7	Баянхонгор сумын Засаг дарга	2021.04.21	45.7
3	Аймгийн төв доторх асфалтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний засвар шинэчлэлт 25000 у/м замд хийх	30.0	Баянхонгор сумын Засаг дарга	2021.04.21	30.0
4	Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх	11.4	Баянхонгор сумын Засаг дарга	2021.04.21	11.4
5	Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфалтан замын хашлага бордюр	27.0	Бууцагаан сумын Засаг дарга	2021.07.23	27.0
Дүн		628.8			523.8

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын захирамжууд**Аудитын илрүүлэлт:**

Дээрх эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдээс Баянхонгор сумын Засаг даргад шилжүүлсэн 496.8 сая төгрөгийн 4, төсөл, арга хэмжээг 2021 оны 04 сард, Бууцагаан сумд шилжүүлсэн замын хашлага бордюрын ажлыг 2021 оны 07 сард шилжүүлсэн байгаа нь ажил эхлүүлэх боломжит хугацаанд эрх шилжүүлээгүй байна.

Иймд цаашид эрхийг шилжүүлэн хэрэгжүүлэх зам, барилгын ажлын эрхийг төсөв батлагдсан даруйд шилжүүлж, гэрээний хугацаандаа хэрэгжих боломжоор хангаж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

Б.1.2. Тайлант онд нийт 1,121.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 2, Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар 1, харьцуулалтын аргаар 10, шууд гэрээ байгуулсан 1 төсөл арга хэмжээ байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Ангилалдаагүй зардлаас орон нутгийн хөрөнгө оруулалтад 2021 онд нийт 540.3 сая төгрөгийн 15 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдсан бөгөөд 324.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Харин 27.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/511 дүгээр захирамжаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4¹³ дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.1.1¹⁴ дэх заалт, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5¹⁵ дахь заалтуудыг үндэслэн шууд гэрээ байгуулсан бол 188.9 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Босго

¹³ Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.

¹⁴ нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх;

¹⁵ гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол;

үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу шууд худалдан авалтын гэрээг байгуулан ажилласан байна.

Хүснэгт № 5 2021 оны худалдан авах ажиллагаанд хамааралгүй ТАХ-ний судалгаа /сая.төгрөг/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв
1	10-р байрны дахин төлөвлөлт	100.0
2	Улсын бүртгэлийн хэлтсийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /Дизель мотор/	5.0
3	Төрийн архивыг баримт сэлбэн засаж, сэргээн шинэтгэх лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2.0
4	Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	3.0
5	Заг, Баянцагаан сумын кабонд засвар, Богд, Шинэжинст, Баянцагаан сумдад кабоныг камержуулах	11.0
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж	20.0
7	Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, Цэвэр хот оффис авах	42.0
8	ЗӨСТ-ийн тоног төхөөрөмж	5.9
	Нийт дүн	188.9

Ангилалдаагүй зардалд 2021 онд батлагдсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс 43.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газарт эрх шилжүүлсэн бөгөөд харьцуулалтын аргаар тендер сонгон шалгаруулалтыг зарласан байна.

Зураг 1. ХАА-нд мөрдсөн журам



Зураг 2. ХАА-нд мөрдсөн журам



Аудитаар аймгийн ОНӨГ-т зохион байгуулсан 295.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын тендерийн баримт бичгийг шалгахад дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Ойн ангид модны суулгацын дэмжлэг олгохоор орон нутгийн төсвөөс 20.0 сая төгрөгийг баталсан бөгөөд аймгийн ЗДТГ-ын даргын 2021.03.24-ны өдрийн тушаалаар тендерийн үнэлгээний хороог байгуулсан байна. Тус үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан Т.Гантөмөрийн АЗ сертификатын хугацаа 2021.01.27-нд дууссан байхад үнэлгээний хорооны гишүүнээр ажиллуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.6¹⁶ дугаар зүйлийг зөрчсөн байна.

¹⁶ Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

Иймд цаашид үнэлгээний хорооны гишүүнийг томилохдоо АЗ сертификатын хүчинтэй эсэхийг шалгаж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

Замын сан:

Замын сангийн хөрөнгө оруулалтаар 2021 онд нийт 947.4 сая төгрөгийн 12 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталсны 295.9 сая төгрөг нь өмнөх оноос шилжиж ирсэн, 15.0 сая төгрөгийн Автозамын тухай хуулийн 24.5¹⁷ дахь заалтын дагуу хяналтын зардалд баталсан бол 636.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын ажил шинээр хийхээр төлөвлөсөн байна.

Дээрх 636.5 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээнээс 25.7 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай” тогтоолын дагуу шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт багтаж 610.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Замын сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлсэн бүх төсөл, арга хэмжээг аймгийн Орон нутгийн өмчийн газар болон эрх шилжүүлсэн Баянхонгор сумын ЗДТГ, Бууцагаан сумын ЗДТГ нь цахимаар зарласан бөгөөд 2021 оны 610.8 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээнээс 409.6 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 151.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 50.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үр дүнд 11.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт бий болсон байна.

Аудитын илрүүлэлт:

“Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфалтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах” ажлын худалдан авах ажиллагааг 2021.08.17-ны өдөр зохион байгуулж ажил гүйцэтгэх гэрээг гүйцэтгэгчтэй 2021.09.08-ны өдөр байгуулсан байгаа нь төсөл, арга хэмжээг хугацаанд бүрэн хэрэгжих боломжийг бүрдүүлээгүй байна.

Аудитаар тус ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгахад бүрэн хэрэгжээгүй, гүйцэтгэгч нь гэрээний хугацаа сунгуулах хүсэлт гаргасны дагуу гэрээний хугацааг сунгасан.

Иймд цаашид улирлын шинж чанартай зам, барилгын ажлын худалдан авах ажиллагааг төсөв батлагдсан даруйд зохион байгуулж, гэрээний хугацаандаа хэрэгжих боломжоор хангаж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8¹⁸ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

¹⁷ Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ;

¹⁸ барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

Б.1.3. Тайлант онд ангилагдаагүй зардлаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шинж чанартай 15 төсөл арга хэмжээнд нийт 540.3 сая төгрөг баталсан бөгөөд 324.0 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Хүснэгт № 6 Ангилагдаагүй зардлаас хэрэгжүүлэх ТАХ-ны гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	ИТХ-аар баталсан дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан огноо
1	Баянхонгор сумын 11, 12, 16, Бөмбөгөр сумын цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулна.	27.0	27.0	БИ БИ ДИ ЭМ ЭМ ХХК	26.5	2021.11.25
2	Аймгийн хэмжээний услалтын системүүдээс бага зардлаар боломжит үр ашиг өгөх услалтын системийг засварлаж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлэх	50.0	50.0	Шинэ санаа ХХК	49.9	2021.06.03
3	10-р байрны дахин төлөвлөлт	100.0	100.0	Зүүн шанд ХХК		
4	Автомашин парк шинэчлэл	148.0	148.0	Мөнххада ХХК	148.8	2021.01.27
5	Цагдаагийн газрыг автомашинаар хангах	43.0	43.0	Руссо моторс ХХК	42.9	2021.02.01
6	Улсын бүртгэлийн хэлтсийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах /Дизель мотор/	5.0	5.0	Би эм жи эл би ХХК	5.0	2021.10.21
7	Төрийн архивыг баримт сэлбэн засаж, сэргээн шинэтгэх лабораторид шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2.0	2.0	БАМТ төв	2.0	
8	Хил хамгаалах туслах хүчний орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	3.0	3.0	Техник импорт ХХК, /БАМТ төв-0.5/	3.0	
9	Заг, Баянцагаан сумын кабонд засвар, Богд, Шинэжинст, Баянцагаан сумдад кабоныг камержуулах	11.0	11.0	Дэвших болор ХХК	11.0	2021.03.29
10	Ойн ангид модны суулгацын дэмжлэг олгох	20.0	20.0	Байгалиа дээдлээ ХХК	19.9	2021.05.17
11	Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргах	27.4	27.4	Чорж бүрд ХХК	18.8	
12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж	20.0	20.0	Хонгор пресс ХХК	20.0	2021.08.03
13	Шүүхийн шинжилгээний албаны автомашин	36.0	36.0	Гэгээн их ХХК	39.7	2021.10.20
14	Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, Цэвэр хот оффис ХАвах	42.0	42.0	XXX CAIDENBEAR	42.0	
15	ЗӨСТ-ийн тоног төхөөрөмж	5.9	5.9	Асэтрэвэл ХХК, Техник импорт ХХК	5.8	2021.10.22
Дүн		540.3	540.3		436.2	

Замын сан:

Тайлант онд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээнд нийт 636.5 сая төгрөг баталсан бөгөөд 6 төсөл арга хэмжээний тендерийг сонгон шалгаруулсан боловч “Аймгийн төв доторх асфалтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний засвар шинэчлэлт 25000 у/м замд хийх” төсөл арга хэмжээний гүйцэтгэгч гэрээ байгуулаагүй байна.

Энэ талаар тодруулахад тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нь хүрэлцэхгүй, мөн тэмдэг тэмдэглэгээ нь 3 жил болоод өнгө төрхөө алддаг учир, 2022 онд Баянхонгор аймгийн 80 жилийн ой болохтой холбоотойгоор 2022 онд хийхээр хойшлуулсан гэсэн шалтгаанаар гэрээ байгуулаагүй байна.

Мөн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаанд 1 оролцогч оролцож гэрээ байгуулсан байна.

Иймд замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа өрсөлдөх боломжоор ханган зохион байгуулж байх шаардлагатай байна.

Хүснэгт №7 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	ИТХ-аар баталсан дүн	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан дүн	Гэрээ байгуулсан огноо
Өмнөх оноос шилжсэн ажил						
1	Баянхонгор аймгийн төвд 2018-2020 онд хийгдсэн хатуу хучилттай 2 км автозамын төсөвт тусгагдаагүй илүү хийгдсэн 0.35 км замын санхүүжилт	951.2	191.2	Их богд зам ХХК	өмнөх оноос шилжсэн	2018.09.25
2	Загийн гол, Бөмбөгөрийн Өлзийт гол, Түйн гол, Нарийний голын хоолтын гармуудад төмөр бетонон гүүрний зураг төслийн ажлын үлдэгдэл санхүүжилт	160.0	80.0	КадСүвэдэй ХХК, Тарвааченбүүлэн ХХК,	өмнөх оноос шилжсэн	2020.05.14
3	Баянхонгор сумын хатуу хучилттай зам дагуу явган хүний зам тавих, хуучин зам засварлах ажлын үлдэгдэл санхүүжилт	145.0	25.0	Их богд зам ХХК	өмнөх оноос шилжсэн	2020.05.07
Тайлант онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ						
1	Шинэ суурьшлын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төслийг хийлгэх	50.0	50.0	Ихэр мөнх ХХК	38.9	2021.10.13
2	"Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх	514.6	409.6	Их богд зам ХХК	514.6	2021.07.30
3	Аймгийн төв доторх хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил 880 м2	45.7	45.7	Их богд зам ХХК	45.7	2021.05.27
4	Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфалтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах.	37.0	37.0	Базардарь ХХК	37.0	2021.09.08
5	Аймгийн төв доторх асфалтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний засвар шинэчлэлт 25000 у/м замд хийх	30.0	30.0	Их богд зам ХХК		
6	Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх	11.4	11.4	Их богд зам ХХК	11.4	2021.05.27
7	Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх	10.0	10.0	Их бадарсан ХХК	10.0	2021.09.25
8	Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфалтан замын хашлага бордюр	27.0	27.0	Холбоогийн 3 хавцгай" ХХК	27.0	2021.09.08
9	Баянхонгор аймгийн төвөөрх хатуу хучилттай автозамуудын тэмдэг тэмдэглэгээ /60/ширхэг	15.0	15.7	БИ БИ ДИ ЭМ ЭМ ХХК	15.7	2021.07.21
2021 оны дүн		750.7	636.4		700.3	

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1¹⁹-д тендерийн урилгыг, 21.4²⁰-д тендер шалгаруулалтын үр дүнг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулахаар заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн урилга, тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нээлттэйгээр цаг хугацаанд нь мэдээлсэн байна.

¹⁹ Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

²⁰ Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ.

Хүснэгт №8 Төсөл арга хэмжээний цахимд мэдээлсэн судалгаа

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	ХАА-нд мөрдөгдсөн журам				Цахим системд тендерийн үр дүнг олон нийтэд нээлттэйгээр мэдээлсэн огноо	Шалгарсан гүйцэт-гэгчийн нэр	Шалгарсан төсөвт өртгийн дүн	
		Эхлэх	Дуусах			Тендер шалгаруулалтын							
						Нээлттэй	Харьцуулалт	Шууд гэрээ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох				
1	Шинэ суурьшилын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төслийг хийлгэх	2021	2021	50.0	50.0				1	1	2021.09.08	Ихэрмөнх ХХК	38.9
2	"Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх	2021	2022	514.6	409.6	1				1	2021.05.24	Их богд зам ХХК	514.6
3	Аймгийн төв доторх хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил 880 м2	2021	2021	45.7	45.7		1			1	2021.05.07	Их богд зам ХХК	45.7
4	Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфалтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах.	2021	2021	37.0	37.0		1			1	2021.08.25	Базардарь ХХК	100.0
5	Аймгийн төв доторх асфалтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний засвар шинэчлэлт 25000 у/м замд хийх	2021	2021	30.0	30.0		1			1	2021.07.26	Их богд зам ХХК	30.0
6	Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх	2021	2021	11.4	11.4		1			1	2021.05.07	Их богд зам ХХК	11.4
7	Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфалтан замын хашлага бордюр	2021	2021	27.0	27.0		1			1	9/10/2021	Холбоогийн гурван хавцгай ХХК	66.9
8	Баянхонгор сумын 11, 12, 16, Бөмбөгөр сумын цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулна.	2021	2021	27.0	27.0		1			1	2021.11.17	Би Би Ди Эм Эм ХХК	26.5
9	Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргах	2021	2021	27.4	27.4			1					
10	Аймгийн хэмжээний услалтын системүүдээс бага зардлаар боломжит үр ашиг өгөх	2021	2021	50.0	50.0		1			1	2021.05.19	Шинэсанаа ХХК	49.6
		2021	2021	50.0	50.0		1			1			
11	Автомашин парк шинэчлэл	2021	2021	148.0	148.0	1				1	2021.01.27	Мөнххада ХХК	148.8
12	Цагдаагийн газрыг автомашинаар хангах	2021	2021	43.0	43.0		1			1			
13	Ойн ангид модны суулгачын дэмжлэг олгох	2021	2021	20.0	20.0		1			1	2021.04.30	Байгалиа дээдлээ ХХК	19.9
14	Шүүхийн шинжилгээний албаны автомашин	2021	2021	40.0	36.0		1			1	2021.10.11	Гэгээн их ХХК	39.7
Дүн				1121.2	1012.2	2	11	1	1	14			1091.9

Аудитын илрүүлэлт:

"Аймгийн төв доторх асфалтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний засвар шинэчлэлт 25000 у/м замд хийх" ажлын гүйцэтгэгчээр "Их богд зам" ХХК шалгарсан ч уг ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулаагүй бөгөөд захиалагч ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3²¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд цаашид захиалагч гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд хууль журамд заасан дараагийн шийдвэрийг нэн даруй гаргаж, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Тайлант онд нэмэлтээр ангилагдаагүй зардал болон замын сангийн хөрөнгөөс 2 төсөл арга хэмжээг ИТХ-аар батлагдаагүй байхад аймгийн Засаг даргын захирамжаар шууд гэрээ байгуулан санхүүжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Тайлант онд аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдаагүй арга хэмжээ буюу Прокурорын газрын албан хэрэгцээнд 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1²² дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

²¹ .«Хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулахаас татгалзсан, эсхүл энэ хуулийн 20.7.2-т заасан нөхцөл үүссэн бол түүнд олгосон гэрээ байгуулах эрхийг захиалагч хүчингүй болгож, удаах "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчтой энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд ийм оролцогч байхгүй бол 30.4-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана;

²² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

Аймгийн Засаг даргын 2021.12.13-ны өдрийн А/749 дүгээр захирамжаар төсөвт зохицуулалт хийн “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн үерийн усны шуудууны зураг төсөв хийлгэх” ажлын гэрээг шууд байгуулан ИТХ-ын хуралдаанаар батлагдаагүй арга хэмжээнд 15.0 сая төгрөг зарцуулсан байна.

Иймд аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлагдаагүй арга хэмжээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Б.1.4. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1²³-д заасны дагуу тендерийн захиалагч худалдан авах ажиллагааны тайланг архивын нэгж болгон хадгалсан бөгөөд хуулийн 49.5²⁴-д заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Сангийн яамны хууль, эрх зүйн газрын худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс 2022.01.03-ны өдөр хүргүүлсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Баянхонгор сумын ЗДТГ болон аймгийн Цагдаагийн газар нь худалдан авах ажиллагааны тайлан холбогдох материалыг аймгийн Засаг даргад хүргүүлж тайлагнасан байна.

Б.2. Аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ийн авто зам хариуцсан мэргэжилтэн хяналт хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Б.2.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ангилагдаагүй зардлаас 2021 онд нийт 540.3 сая төгрөгийн 15 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулан ажилласан байна.

“Баянхонгор сумын 11, 12, 16, Бөмбөгөр сумын цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах” 27.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг “БИ БИ ДИ ЭМ ЭМ” ХХК-тай 2021 оны 12 дугаар сарын 31-ны дотор барааг нийлүүлэхээр 2021.11.25-ы өдөр гэрээг байгуулсан бөгөөд уг ажлын санхүүжилтийг 2021 оны эцэст гүйцэтгэгч компани руу шилжүүлээгүй хөрөнгө оруулалтын барьцаа дансанд авч үлдсэн байна.

²³ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

²⁴ Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

Зураг №4 ТАХ-ны ангилал 2021 он



Зураг №5 Хөрөнгө оруулалтыг салбараар харуулбал 2021 он



Дээрх дүрслэлээс үзэхэд боловсролын салбарт 27.0 сая буюу нийт хөрөнгө оруулалтын 5 хувь, цэрэг, цагдаа батлан хамгаалах салбарт 24 хувь, дэд бүтцийн салбарт 5 хувь, хөдөө аж ахуйн салбарт 12 хувь, бусад салбарт 53 хувийн хөрөнгө оруулалт хийсэн байна.


Замын сан:

Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл арга, хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг Сангийн сайд, дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 47/61 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн замын сангийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх авто зам, замын байгууламжийн ажлыг гүйцэтгэх, хянаж, санхүүжүүлэх журам”-ын 3.3 “Хайгуул, зураг, төсөл, төсвийг **мэргэжлийн байгууллага, хүмүүс тооцож**, аймаг хотын засаг даргаар баталгаажуулна” гэж заасны дагуу “МЦЛ” ХХК нь 4 төсөл арга хэмжээний зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байна.


Замын сангийн хөрөнгөөр 2021 онд 947.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1782.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 932.7 сая төгрөгийн 11 хөрөнгө оруулалтын ТАХ батлагдсан бөгөөд тайлант оны 606.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажилласан байна.

✓ “Шинэ суурьшлын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төслийг хийлгэх” 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Ихэр мөнх ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 10 дугаар сарын 13-аас 2021 оны 12 дугаар сарын 15-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

✓ "Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх" 514.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их богд зам ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 07 дугаар сарын 30-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 08 дугаар сарын 02-аас 2021 оны 09 дугаар сарын 10-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



✓ "Аймгийн төв доторх хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил 880 м²" 45.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Их богд зам" ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 05 дугаар сарын 27-аас 2021 оны 07 дугаар сарын 01-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.




✓ "Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх" 11.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их богд зам ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 05 дугаар сарын 27-аас 2021 оны 07 дугаар сарын 01-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 08 дугаар сарын 26-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.

✓ “Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх” 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Их бадарсан ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 09 дугаар сарын 25-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 09 дугаар сарын 10-аас 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



✓ “Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфальтан замын хашлаг бордюр” 27.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Холбоогийн 3 хавцгай ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 09 дугаар сарын 08-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 08-аас 2021 оны 10 дугаар сарын 08-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



✓ “Баянхонгор аймгийн төвөөр хатуу хучилттай автозамуудын тэмдэг тэмдэглэгээ /60/ширхэг” 15.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр шалгарсан БИ БИ ДИ ЭМ ЭМ ХХК нь уг ажлыг гүйцэтгэхээр 2021 оны 07 дугаар сарын 21-ны өдрөөр гэрээ байгуулсан бөгөөд нь уг ажлыг 2021 оны 10 дугаар сарын 08-аас 2021 оны 10 дугаар сарын 20-ны дотор гүйцэтгэхээр гэрээ байгуулан 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдөр техникийн комисст хүлээлгэн өгсөн байна.



✓ “Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфальтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах” 99.9 сая төгрөгийн гэрээний дүн бүхий ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг 37.0 сая төгрөгийг аймгийн замын сангийн хөрөнгөөр, 62.9 сая төгрөгийг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр Базардарь ХХК-тай гэрээ байгуулсан байна. Дээрх ажлыг гэрээний дагуу 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 09-ний хооронд гүйцэтгэхээр байсан ч цаг агаар хүйтэрсэнтэй холбоотойгоор дээрх ажлыг бүрэн гүйцэтгээгүй бөгөөд гүйцэтгэгч компани нь 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 21/20 дугаартай албан бичгээр аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -т гэрээний хугацааг сунгах хүсэлт гаргасны дагуу 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хүртэл сунгасан байна.



Аудитын илрүүлэлт:

“Баянхонгор сумын төв дундах шороон замыг асфалтан хучилттай хар зам болгож, тоосжилтыг багасгах” ажлыг техникийн тодорхойлолттой тулган үзэхэд Баянхонгор аймгийн төвийн 25 км авто замын гарцын ажлыг 12 хэсэг газарт гүйцэтгэхээр байхад техникийн тодорхойлолтод зааснаас өөр газарт буюу орон сууцны гаднах зогсоолын талбайд бетонон хучилт хийсэн байгаа нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28²⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд цаашид Аймгийн ИТХ-аар батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, зориулалт, байршлыг өөрчлөн өөр арга хэмжээнд зарцуулахгүй байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад өгөв.

Б.2.2 Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 4.1-т²⁶ заасны дагуу аймгийн Засаг дарга замын сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлуудад хяналтыг тавьж ажиллах үүрэгтэй байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ийн зам, тээврийн бодлого хариуцсан мэргэжилтэн нь “Зам, тээврийн салбарын хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх” чиг үүрэгтэй хэдий ч аудитаар дээрх замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлуудад хийсэн явцын хяналтын тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ээс ирүүлээгүй болно.

Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 665.7 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг Баянхонгор сумын ЗДТГ-т эрх шилжүүлсэн бөгөөд хүлээн авсан комисст аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ийн зам, тээврийн бодлого хариуцсан мэргэжилтнийг оролцуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтод зааснаас өөр газарт ажил хийгдсэн, явцын хяналт зэргийг хийгээгүйгээс үзэхэд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Иймд цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулан эрх шилжүүлсэн ТАХ-г хүлээн авахдаа аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс бараа ажил үйлчилгээ хүлээн авах комисст оруулан хяналтыг сайжруулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

²⁵ Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно;

²⁶ Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга улс, нийслэл, орон нутгийн авто замын сангийн хөрөнгийг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн тус тус эрхлэн явуулна.

Б.2.3. Баянхонгор сумын Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/112 дугаар захирамжаар Орон нутгийн хөгжлийн сан болон замын сангийн хөрөнгөөр эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хяналт хийх ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллажээ.

Тус ажлын хэсэг нь 2021 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр “Аймгийн төв доторх 8 ш хурд сааруулагч хийх”, “Аймгийн төв доторх хатуу хучилттай автозамын нөхөөсний ажил 880 м²”-ны ажлуудыг, 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд “Есөн эрдэнэ” захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх” ажлуудад тус тус явцын техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Б.2.4 Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явцад хийсэн техникийн хяналтаар ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй, ажлын хэсгээс үүрэг даалгавар өгөөгүй байна.

Б.3. Төсөл, арга хэмжээний аймгийн ИТХ-аар батлагдсан төсвийг 4.5 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн, хөрөнгө оруулалтаар бий болсон 193.7 сая төгрөгийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоож хөрөнгөд бүртгээгүй байна.

Б.3.1. Тайлант онд замын сангийн хөрөнгөөр тайланд онд хэрэгжүүлэхээр баталсан 12 төсөл, арга хэмжээг 869.9 сая, ангилагдаагүй зардлаас хэрэгжүүлэхээр баталсан 14 арга хэмжээг 508.4 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна.

<i>Хүснэгт №4 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын судалгаа</i>						<i>/сая төгрөг/</i>	
№	Зардлын эх үүсвэр	Батлагдсан дүн		Санхүүжих дүн		Олгосон санхүүжилт	Дутуу санхүүжилт
		Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Замын сангийн 2021 оны хөрөнгө оруулалт	12	1,782.9	12	947.7	898.8	142.4
2	Ангилагдаагүй зардалд 2021 оны хөрөнгө оруулалт	15	540.3	14	540.3	508.4	31.9
Нийт		27	2323.2	26	1488	1407.2	174.3

Замын сангийн 2021 онд хэрэгжүүлэхээр батлагдсан "Есөн эрдэнэ" захын баруун талаас Хонгор хотхон хүртэлх хатуу хучилттай автозам дээр хучилт хийх, 500м явган зам шинээр хийх"-ийн ажлыг 514.6 сая төгрөгийн гэрээ байгуулснаас тайлант онд гүйцэтгэгчид 409.6 сая төгрөгийг санхүүжилт олгохоор баталсны дагуу уг санхүүжилтийг олгосон байна.

Ангилагдаагүй зардлын жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 2021 онд санхүүжих нийт 540.3 сая төгрөг олгохоос 508.4 сая төгрөг олгосон байна.

“Баянхонгор сумын ундны усны эх үүсвэрт худаг гаргах” төсөл арга хэмжээнд нийт 27.4 сая төгрөг баталсан бөгөөд тайлант онд 18.8 сая төгрөгийн санхүүжилтийг “Чоржбүрд” ХХК-д шилжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

-Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд 148.0 сая төгрөгөөр Автомашин худалдан авахаар тендер шалгаруулж гэрээ хийхдээ 148.8 сая төгрөг буюу 0.8 сая төгрөгөөр төсөвт өртгийг хэтрүүлсэн;

- Шүүхийн шинжилгээний албаны автомашиныг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 36.0 сая, ШШҮХүрээлэнгээс 4.0 сая нийт 40.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан бөгөөд тендерт шалгарсан компанид орон нутгийн төсвөөс 39.7 сая төгрөг буюу төсөвт өртгийг 3.7 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2²⁷ дахь заалттай нийцэхгүй байгаа тул дээрх батлагдсан төсвөөс илүү санхүүжүүлсэн 4.5 сая төгрөгийг орон нутагт буцаан төлүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

Б.3.2. Тайлант онд ангилагдаагүй зардлаас нийт 528.4 сая төгрөгийн 15 хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээ, замын сангийн 2021 оны хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 107.7 сая төгрөгийн 4 хөрөнгийн эзэмшигчийг тогтоосон эсэхийг шалгахад 193.7 сая төгрөгийн хөрөнгийг эзэмшигчийг тогтоож бүртгээгүй байгаа нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн 40 дугаар тогтоолоор “Орон нутгийн өмчид эд хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, акталж данснаас хасах журам”-ын 4.3²⁸ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон нийт 193.7 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгөд бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6²⁹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1³⁰ дэх заалттай нийцэхгүй байна. Үүнд:

- “Аймгийн хэмжээний услалтын системүүдээс бага зардлаар боломжит үр ашиг өгөх услалтын системийг засварлаж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлэх”-д шаардлагатай 49.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бараа материалыг аймгийн ЗДТГ-ын даргын 2021.07.09-ний өдрийн А/132 дугаар тушаалаар томилсон комисс хүлээн авсан;

- “Богд, Шинэжинст, Баянцагаан сумдад кабоныг камержуулах” 7.8 сая төгрөгийн өртөг бүхий камерыг Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газар комиссын актаар хүлээн авсан;

- “Шүүхийн шинжилгээний албаны автомашин” 39.7 сая төгрөгийн өртөг бүхий Toyota Hiace маркийн автомашиныг Гэгээн их ХХК-иас комиссын актаар хүлээн авсан ;

- “Шинэ суурьшлын бүсийн 8.5 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төслийг хийлгэх” 38.9 сая төгрөгийн өртөг бүхий зураг төсөө;

- 27.0 сая төгрөгийн өртөгтэй “Бууцагаан сум дундах хатуу хучилттай асфальтан замын хашлага бордюр”

- Баянхонгор аймгийн төвийн хатуу хучилттай автозамуудын тэмдэг тэмдэглэгээ /60/ширхэг 15.7 сая төгрөгийн өртөгтэй;

- “Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн үерийн усны шуудууны зураг төсөө хийлгэх” 15 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсөө.

²⁷ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

²⁸ “Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд улсын болон орон нутгийн төвлөрсөн төсвөөс хөрөнгө оруулалт хийж үндсэн хөрөнгө бэлтгэсэн тохиолдолд хөрөнгийн үнэ өртөг, тоо хэмжээг тухайн хөрөнгийн санхүүжилтийг хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч болон төвлөрүүлэн захирагчийн зөвшөөрлийг авч эзэмшигч байгууллага нь шууд данс бүртгэлд тусгана”

²⁹ “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”

³⁰ “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”

Иймд дээрх 193.7 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хариуцуулан өглөө.

Б.4.Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, алдаа, зөрчил гарсаар байна.

Б.4 Орон нутгийн төсвийн 2019, 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 903.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 45.8 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 604.0 сая төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 253.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 8 зөвлөмж өгсөн байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	45.8	4	45.8			100
Албан шаардлага	8	604	8	604			100
Зөвлөмж	7	253.3			7	253.3	0
Нийт дүн	19	903.1	12	649.8	7	253.3	66.7

Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байгаа бол зөвлөмжийг хэрэгжилтийг биелэлтийг ирүүлээгүй ба аудитаар зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаар авч үзэхэд өмнөх онд гарсан алдаа, зөрчил давтагдан гарсан, зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

№	Өгсөн зөвлөмж	Аудитаар тооцсон биелэлт
1	Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахдаа аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан тухайн жилийн үндсэн чиглэлд туссан, зорилтод хүрэх түвшнийг тодорхойлсон төсөл арга хэмжээ баталж байх.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоног төхөөрөмж, Шүүхийн шинжилгээний албаны автомашин, Хот тохижилт үйлчилгээ ОНӨҮГ, "Цэвэр хот" ОНӨААН-д оффис худалдан авах ажлууд нь Баянхонгор аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Биелэлт 70%
2	Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулан эрх шилжүүлсэн ТАХ-г хүлээн авахдаа аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсээс бараа ажил үйлчилгээ хүлээн авах комисст оруулан техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, чанартай бараа, ажил үйлчилгээг хүлээн авч, хяналтыг сайжруулах.	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 665.7 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг Баянхонгор сумын ЗДТГ-г эрх шилжүүлсэн бөгөөд хүлээн авсан комисст аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ -ийн Тээврийн бодлого-автозамын асуудал хариуцсан мэргэжилтнийг оролцуулаагүй байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Биелэлт 0%
3	Ажлын хариуцлагагүй байдлаас шалтгаалж, хөрөнгө оруулалтын үр дүнгийн биелэлтийг тооцоогүй, хяналт тавих үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлүүд давтагдан гарч байгаад анхаарлаа хандуулж холбогдох албан тушаалтнуудад сургалт зохион байгуулж, аттестатчилан, ажилд хандах хандлага, үр чадварыг нэмэгдүүлэх.	Хэрэгжсэн.
4	Баян-Овоо сумын соёлын төвийн автомашины эзэмшигчийн гэрчилгээг тухайн байгууллагын нэр дээр шилжүүлж, Онцгой байдлын автомашинд ашиглалтын гэрээ байгуулж ажиллах.	Хэрэгжүүлсэн.
5	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгохдоо зээлийн хорооны шийдвэрээр санхүүжилт нь хасагдсан төслийн зээлдэгчээс үйл ажиллагаа явуулах эсэх талаар төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас тодорхойлолтыг авч, зээлийг олгож байх.	Хэрэгжүүлсэн.
6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг хийхдээ аймгийн хэмжээний төсөв захирагчдын хэрэгцээ шаардлагыг судалж, хэрэгцээ шаардлагыг эрэмбэлэн, хүрэх түвшнийг тодорхойлон, эдийн засгийн үр ашиг, нийгмийн үйлчилгээний хүртээмж, бусад	Замын сангийн 2021 оны хөрөнгө оруулалтаас 893.8 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө баг хороо, авто тээврийн төв, замын цагдаа зэрэг холбогдох байгууллагуудаас санал аваагүй байгаа нь зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүй байна. Биелэлт 0%

№	Өгсөн зөвлөмж	Аудитаар тооцсон биелэлт
	холбогдох ач холбогдлоор нь эрэмбэлэн төлөвлөлтийг зохистой хийх.	
7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулахдаа хяналтын үйл ажиллагаа явуулж буй /Тухайлбал: замын сангийн хөрөнгийн зарцуулалт дээр авто тээврийн газар, цагдаа г.м/ мэргэжлийн байгууллагуудаас санал авч, зураг төсвийг урьдчилан боловсруулж, магадлалын дүгнэлт гаруулсны дараа батлуулж, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.	
8	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэхдээ багцаар баталсан төсөл арга хэмжээний үнийн дүнг хянаж, ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн холбогдох албан тушаалтанд арга хэмжээ авч, цаашид худалдан авах ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газраар зохион байгуулуулж ажиллах.	Хэрэгжүүлсэн.
НИЙТ ДҮН		Биелэлтийн дундаж 58.8%

Аудитаар нийт 366.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж 4.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 193.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгч, 168.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 6 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын 3 төсөл арга хэмжээ дунд болон богино хугацааны бодлоготой уялдаагүй ба замын сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө журмын дагуу санал аваагүй байна.
2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг хууль, журамд заасан хугацаанд эрх шилжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хугацаа алдаж зохион байгуулснаас 37.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.
3. Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу ил, тод нээлттэй, тэгш өрсөлдөх боломжоор хангаж зохион байгуулсан байна.
4. Баянхонгор аймагт 2021 онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1427.3 сая төгрөгийн 26 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангуулж, 56.5 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.
5. Аймгийн замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
6. Аймгийн ИТХ-аар батлагдсан төсвийг 4.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.
7. Хөрөнгө оруулалтаар бий болсон 193.7 сая төгрөгийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, хөрөнгөд бүртгээгүй байна.
8. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, давтагдан гарсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Орон нутгийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийг төлөвлөхдөө холбогдох газраас санал авч, дунд болон богино хугацааны хөгжлийн баримт бичигтэй уялдуулах.
2. Улирлын шинж чанартай зам, барилгын ажлын худалдан авах ажиллагааг төсөв батлагдсан даруйд зохион байгуулж, гэрээний хугацаандаа хэрэгжих боломжоор хангаж ажиллах, мөн эрхийг шилжүүлэн хэрэгжүүлэх зам, барилгын ажлын эрхийг төсөв батлагдсан даруйд шилжүүлж байх.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих хяналтыг сайжруулан гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийг чанартай бүрэн хангуулж ажиллах.
4. ИТХ-ын хуралдаанаар батлагдаагүй арга хэмжээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох.
5. Захиалагч гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд хууль журамд заасны дагуу шуурхай шийдвэрлэж батлагдсан төсөл арга хэмжээний үр дүнтэй хэрэгжүүлэх.
6. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй, алдаа, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.